







БАРИМТ БИЧГИЙГ ТАРААСАН БҮРТГЭЛ

2024 оны 5 дугаар сарын 21

Баримт бичгийн нэр		Баримт бичгийн тэмдэглэгээ		
Аймгийн Засаг даргын 1 дүгээр улиралд бүртгэл хяналтад авсан захирамжийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийсэн тайлан				
Баримт бичгийг хүлээн авсан:				
№	Албан тушаал	Нэр	Гарын үсэг	Огноо
1	Засаг даргын Тамгын газрын дарга	Л.Доржбат		2024.06.11
2	Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга	Н.Түвшинжаргал		2024.6.11
2	Хяналт шинжилгээ үнэлгээний хэлтсийн дарга	Д.Даариймаа		2024.6.12
3	Хууль эрх зүйн хэлтсийн дарга	Л.Баярсайхан		2024.6.11
4	Нийгмийн бодлогын хэлтсийн дарга	Н.Эрдэнэ-Очир		2024.06.11
5	ХБТХОХ-ийн мэргэжилтэн	Ж.Уянга		2024.06.11

Бүртгэл хөтөлсөн:
ХШҮХ-ийн мэргэжилтэн



Б.Солонго

**АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН 2024 ОНЫ 1 ДҮГЭЭР УЛИРАЛД БҮРТГЭЛ ХЯНАЛТАД
АВСАН ЗАХИРАМЖИЙН ХЭРЭГЖИЛТЭД ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ ҮНЭЛГЭЭ
ХИЙСЭН ТАЙЛАН**

2024 оны 05 дугаар сарын 03

Мандалговь хот

НЭГ. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ЗОРИЛГО

Аймгийн Засаг даргын 2024 оны 1 дүгээр улиралд батлан гаргасан захирамжийн хэрэгжилтийн үр дүнг үнэлэх, зөвлөмж гаргах, удирдлагыг үнэн зөв, бодит мэдээллээр хангах, захирамжийн хэрэгжилтийн үр нөлөөг нэмэгдүүлэх, хэрэгжилт, зохион байгуулалт, хариуцлагыг сайжруулахад хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго оршино.

ХОЁР. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ҮНДЭСЛЭЛ, АРГА ЗҮЙ

Аймгийн Засаг даргын 2024 оны 1 дүгээр улиралд батлан гаргасан хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээг Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 6.3-т заасан аргачлалаар хийлээ.

Аймгийн Засаг даргаас 2024 оны 1 дүгээр улиралд 21 захирамжийн 21 заалтыг хяналтад авч, Төрийн захиргааны, удирдлагын хэлтэс холбогдох сум, хэлтэс, агентлагуудаас биелэлтийг гаргуулан авч нэгтгэн тайланг 2024 оны 4 сарын 24-ний өдөр эцсийн байдлаар ирүүлсэн.

ГУРАВ. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ ҮНЭЛГЭЭНИЙ ҮР ДҮН

Аймгийн Засаг даргын 2024 оны 1 дүгээр улиралд хяналтад авсан 21 захирамжийн 21 заалт 88.5 хувийн хэрэгжилттэй байна. Үүнээс 100 хувь -15, 70 хувь -2, 50 хувь -2, 30 хувь -1 заалт байна.

Дүнгээс харахад: Бүрэн хэрэгжсэн буюу 100 хувьтай 15 заалт нь нийт заалтын 71.4 хувийг, хэрэгжих шатандаа буюу 70 хувьтай хэрэгжиж байгаа 2 заалт нь 9.5 хувийг, хэрэгжилт хангалтгүй буюу 50 хувьтай хэрэгжиж байгаа 2 заалт 9.5 хувийг,

хэрэгжилт хангалтгүй буюу 30 хувьтай хэрэгжиж байгаа 1 заалт нь 4.8 хувийг, хугацаа болоогүй 1 заалт 4.8 хувийг тус тус эзэлсэн байна.

Явцын дүнг хүснэгтээр харуулбал:

д/д	Шийдвэрийн нэр	Заалтын тоо	Хэрэгжилтийн хувь						Хэрэгжилтийн дундаж хувь
			100	90	70	50	30	ХБ	
1	Аймгийн Засаг даргын 1 дүгээр улирлын захирамж	21	15	-	2	2	1	1	88.5



ҮР ДҮНТЭЙ ХЭРЭГЖИЖ БАЙГАА ОНЦЛОХ АРГА ХЭМЖЭЭНҮҮДЭЭС ДУРДВАЛ:

1.Аймгаас 2024 оныг Хүүхэд, гэр бүл, хөгжил хамгааллыг дэмжих жил болгож зарласантай холбогдуулан “Хүүхдийн шим тэжээл хоол” 2-р уралдаан зохион байгуулагдаж шилдгүүдээ тодруулж, Япон улсын санхүүжилтээр Жайка олон улсын байгууллагын хэрэгжүүлж буй ерөнхий боловсролын сургуулийн үдийн хоол үйлдвэрлэлийг дэмжих төслийн хүрээнд туршлага солилцох үйл ажиллагааг зохион байгуулсан.




2. Үндэсний дээл хувцсаа өмсөж хэвших уриалга гаргаж тус захирамжийн хүрээнд аймгийн бүх төрийн байгууллага нэгдэж сар бүрийн 3 дахь 7 хоногийн лхагва гаригт үндэсний дээл, хувцсаа өмсөж хэвшиж эхлээд байна. Аймгийн Засаг даргын тамгын газрын эрхлэх хүрээний нэгж, агентлаг болон болон бусад байгууллагын 137 удирдлага, мэргэжилтэн, албан хаагчдад үндэсний хувцсаа өмсөж хэвшиж байгаад талархсан Соёл урлагийн газрын ажилтнуудын хийсэн

Үндэсний бичгээр бичсэн талархлын үгтэй номын хавчуургыг дурсгаж, нөлөөллийн ажлыг зохион байгуулсан байна.



3. “Та татгалз-Бид дэмжье” сэдэвт зорилтот бүлгийн иргэдийг хамруулан нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулж “Архи, согтууруулах ундаа, хүний биед үзүүлэх хор нөлөө, мэргэжлийн эмчийн хяналтад хийгдэж буй архины хордлого тайлах, архинд донтох эмгэгийн эмчилгээний талаарх мэдээлэл, “Говийн хийморь” АА бүлгийн ухаарлын яриа таниулга, “Хувь хүн өөрийгөө олох нь” сэдвээр сургалтыг хийсэн байна.



Энэ улиралд хэрэгжилт тооцсон захирамжуудаас дараах заалт хэрэгжилт удаашралтай байгаа болон эрчимжүүлэх шаардлагатай байна.

№	Шийдвэрийн огноо дугаар	Шийдвэрийн утга	Заалт	Хэрэгжилтийн явц	Шалтгаан
1	2024.02.07	Тэргүүлэх чиглэл батлах тухай	A/56	50	Зохион байгуулалт

ДӨРӨВ. ДҮГНЭЛТ

Аймгийн Засаг даргын баталсан захирамжийн хэрэгжилтийн явцад улирал бүр хяналт шинжилгээ, үнэлгээг хийж холбогдох хэлтэс, байгууллагуудад зөвлөмж өгч үр дүнг тооцон ажиллаж байна.

Цаашид өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх, хэрэгжилтэд хяналт тавих шаардлагатай байна.

2024 оны 1 дүгээр улиралд Аймгийн Засаг даргаас батлан гаргасан захирамжийн хэрэгжилт 88.5 хувьтай хэрэгжиж, өмнөх оны мөн үеэс 0,7 хувиар өссөн байна.

Нэг удаагийн шинжтэй 15 заалтаар үүрэг өгөгдсөний 13 заалт нь 100% хэрэгжиж 1 заалт 70 хувь, хугацаа болоогүй 1 заалт байна. Байнга тасралтгүй хэрэгжих 6 заалтын 2 заалт нь 100%-тай байна. 70 хувьтай 1, 50 хувьтай 2, 30 хувьтай 1 байна. Иймээс байнга тасралтгүй хэрэгжих заалт удаашралтай байгаад хяналт тавих шаардлагатай байна.

2024 оны 1-р улирлын байдлаар нийт 21 захирамжийн 21 заалтаас 8 заалтын хэрэгжилтийг ХБТХОХ болон харьяа хэлтэс, агентлагуудад хамааралтай гаргаж хэрэгжилтийн дундаж 93,7 хувьтай байна. НБХ болон харьяа хэлтэс, агентлагуудад хамааралтай 5 заалтын хэрэгжилтийн дундаж 60хувь, СТСХ болон харьяа хэлтэс, агентлагуудад хамааралтай 3 заалтын дундаж 73,3 хувь, ТЗУХ, ХЭЗХ, ЦШ эдгээр хэлтсүүдэд болон харьяа хэлтсүүдэд хамааралтай 4 заалт 100 хувийн биелэлттэй байна.

ТАВ. ЗӨВЛӨМЖ

1. 2024 оныг Хүүхэд, гэр бүл хөгжил хамгааллын жилийн ажлын хүрээнд сум, агентлагуудын төлөвлөгөөний хэрэгжилтийн эхний хагас жил болон жилийн эцсээр гаргуулан авч хэрэгжилтийн байдлыг нэгтгэн тайлагнаж байхаас гадна зарцуулсан хөрөнгийн хэмжээг тооцон гаргуулах. **/Төрийн захиргааны удирдлагын хэлтэст/**

2. Тэргүүлэх чиглэлээ батлуулаагүй 7 сумыг ИТХ-аар батлуулсан эсэхэд хяналт тавьж төсөл хүлээн авах зарыг олон нийтэд ил тод, хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчлах **/Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс/**

3. Бага насны хүүхдийн цогц хөгжлийг дэмжих орон тооны бус Орон нутгийн зөвлөлийн ажиллах дүрмийг боловсруулан батлуулах, төлөвлөгөөний

хэрэгжилтийн тайланг нэгтгэн тайлагнаж зарцуулсан хөрөнгийн хэмжээг тооцон гаргах./Нийгмийн бодлогын хэлтэст/

4. Зарцуулсан хөрөнгийн хэмжээг заавал гаргаж ирүүлэх /Төрийн захиргааны удирдлагын хэлтэст /

Бодлогын хэлтсүүд өгсөн зөвлөмжийг холбогдох хэлтэс, агентлагууддаа хүргүүлэн хэрэгжилтэд нь хяналт тавин тайланг 2 дугаар улирлын захирамжийн хэрэгжилтийн хамт ирүүлэх

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТЭС

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГААС 2024 ОНЫ 1 ДҮГЭЭР УЛИРАЛД БАТЛАН ГАРГАСАН ЗАХИРАМЖИЙН ХЭРЭГЖИЛТ

2024 оны 03 дугаар сарын 29-ны өдөр

Мандалговь хот

№	Захирамжийн дугаар	Шийдвэрийн нэр, огноо, дугаар	Заалтын дугаар	Заалт	Хариуцан хэрэгжүүлэх байгууллага	Хэрэгжилт, үр дүн	Хувь
1	A/527	Харьяа агентлагуудын төрийн захиргааны албан хаагчдад орон нутгийн нэмэгдэл олгох тухай 2023.09.15	1	2.Орон нутгийн нэмэгдлийг улирал бүр албан хаагчийн ажлын гүйцэтгэлд хяналт-шинжилгээ хийж дүгнэж олгох ажлыг зохион байгуулахыг аймгийн Засаг даргын Тамгын Газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтэс (Н.Түвшинжаргал), Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс (Д.Даариймаа) нарт тус тус даалгасугай.	ТЗУХ ХШҮХ	Харьяа агентлагуудын төрийн захиргааны албан хаагчдад орон нутгийн нэмэгдлийг улирал бүр олгох аргачлалыг боловсруулан Засаг даргаар батлуулж аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний харьяа агентлагуудын төрийн захиргааны албан хаагч нарын 1 дүгээр улирлын үнэлгээг хийж улсын төсвийн байгууллагын 221 төрийн албан хаагч 102.7 сая төгрөг, орон нутгийн өмчит байгууллагын 26 албан хаагч 14.1 сая төгрөгийг олгосон.	100
2	A/01	Хүүхэд, гэр бүл хөгжил хамгааллын жил болгон зарлах тухай 2024.01.02	2	5. Хүүхэд, гэр бүл хөгжил хамгааллын жилийн ажлын төлөвлөгөө боловсруулан батлуулж, удирдлага зохион байгуулалтаар хангаж, хэрэгжилт үр дүнг тооцон аймгийн Засаг даргын зөвлөлийн хуралд тайлагнаж ажиллахыг ажлын хэсэг (М.Анхбаяр)-т, 2024 оны ажлын	НБХ	Хүүхэд, гэр бүл, хөгжил хамгааллыг дэмжих жилийн ажлын төлөвлөгөөг 5 чиглэлийн хүрээнд 47 арга хэмжээг УТ-360.9, ОНТ-2396.6, хандив, дэмжлэг-3.0 сая төгрөгөөр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн. Сумдын засаг дарга болон албан байгууллагын дарга	70

				<p>төлөвлөгөөндөө зорилт арга хэмжээг тусган шаардагдах зардлын эх үүсвэрийг шийдвэрлэж ажиллахыг төрийн байгууллага, сумдын Засаг дарга нарт тус тус даалгасугай.</p>		<p>нарт аймгийн засаг даргын 2024.03.05-ны өдрийн 01/280 тоот албан бичгээр жилийн ажлын төлөвлөгөөг хүргүүлж, тухайн сум, байгууллагын дэмжих жилийн ажлын төлөвлөгөөг баталж, хэрэгжилтийн тайланг хагас, бүтэн жилээр тайлагнахыг чиглэл болгож хэрэгжилтийг ханган ажиллаж байна.</p>	
3	A/02	<p>Үндэсний дээл хувцсаа өмсөж хэвших уриалга гаргах тухай 2024.01.02</p>	3	<p>4. Дээрх уриалгыг албан байгууллага, аж ахуйн нэгжүүдэд сурталчлан таниулах ажлыг зохион байгуулж хэрэгжилтийг хагас, бүтэн жилээр тайлагнаж ажиллахыг Соёл урлагийн газар (Х.Цогзолмаа)-д даалгасугай.</p>	СУГ	<p>Тус захирамжийн хүрээнд аймгийн бүх төрийн байгууллага нэгдэж сар бүрийн 3 дахь 7 хоногийн лхагва гаригт үндэсний дээл, хувцсаа өмсөж хэвшиж эхлээд байна. Цахим орчинд 17 сум, байгууллага монгол дээл, хувцас өмсөх, тэдгээртэй холбогдох зан заншил, өв соёлтой, холбогдох 25 мэдээлэл, богино бичлэг, үйл ажиллагааны мэдээг бэлтгэн оруулж 50282 хүний хандалт авч 50 удаагийн үйл ажиллагаа зохион байгуулж давхардсан тоогоор 1560 иргэнийг хамруулан сурталчилгаа хийж ажилласан. Аймгийн Засаг даргын тамгын газрын эрхлэх хүрээний нэгж, агентлаг болон болон</p>	100

						бусад байгууллагын 137 удирдлага, мэргэжилтэн, албан хаагчдад үндэсний хувцсаа өмсөж хэвшиж байгаад талархсан Соёл урлагийн газрын ажилтнуудын хийсэн Үндэсний бичгээр бичсэн талархлын үгтэй номын хавчуургыг дурсгаж, нөлөөллийн ажлыг зохион байгуулсан.	
4	A/05	Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх тухай 2024.01.04	4	2. Өвөлжилтийн нөхцөл байдалтай холбогдуулан аймаг, сумын хэмжээнд өвс, тэжээлийн нөөцийг нэмэгдүүлж ажиллахыг Хүнс, хөдөө аж ахуйн газар (Б.Мөнхжаргал), сумдын Засаг дарга нарт даалгасугай.	ХХААГ Сумдын Засаг дарга нар	Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэнтэй зэрэгт холбоотойгоор сумдын удирдлагуудад үүрэг болгосонтой 975.1 тн өвс, 317.8 тн тэжээлийн аюулгүй нөөцөд татан авалтаар бүрдүүлж нийт 7000 малчдад хуваарилан олгож 295 сая төгрөгийг зарцуулсан.	100
5	A/06	Архи согтууруулах ундаа худалдан борлуулах, түүгээр үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл олгох тухай 2024.01.08	5	2. Гарсан шийдвэрийг холбогдох газруудад хуулийн хугацаанд мэдэгдэхийг Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс (Л.Доржбат), тухайн аж ахуй нэгжийн үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллахыг Цагдаагийн газар (Б.Мөнхбат), Татварын хэлтэс (М.Туяацэцэг), холбогдох сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.	ХБТХОХ ЦГ ТХ Сумдын Засаг дарга нар	Сайнцагаан, Дэрэн, Дэлгэрхангай, Цагаандэлгэр, Гурвансайхан, Луус зэрэг 6 сумын 18 худалдааны газар, 3 зоогийн газар нийт 21 ААН-д тусгай зөвшөөрөл олгож орон нутгийн орлогын дансанд нийт 19.3 сая төгрөг төвлөрүүлсэн. Тус захирамжаар архи согтууруулах ундаа худалдан борлуулах,	100

					<p>түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл олгогдсон байгууллагуудад холбогдох хууль тогтоомжийг тайлбарлан өгч зөрчил дутагдал гаргуулахгүй байхад хэсгийн байцаагч, сумдын төлөөлөгч, эргүүлийн үүрэг гүйцэтгэж байгаа эргүүлийн цагдаа нар тогтмол хяналт тавин ажиллаж байна.</p> <p>Тус захирамжаар архи согтууруулах ундаа худалдан борлуулах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл олгогдсон байгууллагуудад холбогдох хууль тогтоомжийг тайлбарлан өгч зөрчил дутагдал гаргуулахгүй байхад хэсгийн байцаагч, сумдын төлөөлөгч, эргүүлийн үүрэг гүйцэтгэж байгаа эргүүлийн цагдаа нар тогтмол хяналт тавин ажиллаж байна.</p>	
6	A/07	Төсвийн сар, улирлын хуваарь батлах тухай 2024.01.08	6	2. Батлагдсан хуваарийн дагуу тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагын санхүүжилтийг олгож хэрэгжилтийг хянаж, төсвийн гүйцэтгэлийг сар бүр үнэн зөв мэдээлж, төсвийн ил тод байдлыг хангаж ажиллахыг Санхүү,	Орон нутгийн төсөвт байгууллагуудын санхүүжилтийг батлагдсан хуваарийн дагуу бүрэн хугацаанд олгож, төсвийн орлого зарлагын гүйцэтгэлийн мэдээллийг хугацаанд холбогдох байгууллагад хүргэж	100

				төрийн сангийн хэлтэс гүйцэтгэгч (Г.Энхтайван)-д үүрэг болгосугай.		шилэн дансанд бүрэн байршуулсан.	
7	A/11	Ажлын хэсэг томилох тухай 2024.01.11	7	2. Ойн үйл ажиллагааг зохион байгуулах тусгай төлөвлөгөө гарган хэрэгжүүлж, үр дүнг тооцож ажиллахыг ажлын хэсэг (Н.Эрдэнэ-Очир)-т үүрэг болгосугай.		Зууны манлай алдарт уртын дуучин МУГЖ Ж.Дорждагвын 120 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх ажлын хүрээнд аймгийн ажлын хэсэг байгуулагдаж бэлтгэл ажлын төлөвлөгөөг батлан хэрэгжилтийг ханган ажиллаж байна. "Дурьтмал сайхан" Олон Улсын есвөрийн уртын дуучдын уралдаан, "Яргуй" урлагийн бага наадмын албан бичиг боловсруулан батлуулж 21 аймаг, сумдын дарга нарт хүргэсэн. Соёлын яаманд ойн арга хэмжээ зохион байгуулах тухай Засгийн газрын тогтоолын саналыг хүргүүлж ажилласан.	100
8	A/18	Улсын нөөцөөс хямдруулан олгох тэжээлийг сумдад хуваарилах тухай 2024.01.17	8	3. Дээрх ажлыг зохион байгуулж хяналт тавихыг Онцгой байдлын газар (Ц.Төрбилэг), хүнс хөдөө аж ахуйн бодлого хариуцсан мэргэжилтэн (Х.Дашням) нарт даалгасугай.	ХБТХОХ ОБГ	Засгийн газрын 2023 оны 449, 479 дүгээр тогтоолын дагуу өвөлжилт хүндэрсэн зарим аймгуудад улсын нөөцөөс тэжээлийг 50 хувь хямдруулан олгох шийдвэрийн дагуу аймгийн Засаг даргын 2024 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн А/18 дугаар захирамжийн дагуу 052, 086, 124 дүгээр салбар, цэгүүдээс өвөлжилтийн	100

						нөхцөл байдал, сум орон нутгийн байршлаас хамааруулан 15 сумд олгох хуваарь гарган олгож малчдад бүрэн олгосон.	
9	A/39	Хүүхдийн хөгжил сангийн журам батлах тухай 2024.01.23	9	3. Журмыг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлыг төсөвт тусган санхүүжүүлэхийг Санхүү төрийн сангийн хэлтэс (Г.Энхтайван)-д даалгасугай.	СТСХ	Хүүхдийн хөгжил сангийн журам баталж зардалд 100,0 сая төгрөгийг төсөвт тусган санхүүжүүлж одоогийн байдлаар 9,0 сая төгрөгийг “Дорнод 2024” идэрчүүдийн улсын аварга шалгаруулах волейболын тэмцээнд зарцуулаад байна.	50
10	A/41	Архи согтууруулах ундаа худалдан борлуулах, түүгээр үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл олгох тухай 2024.01.24	10	2. Гарсан шийдвэрийг холбогдох газруудад хуулийн хугацаанд мэдэгдэхийг Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс (Л.Доржбат), тухайн аж ахуй нэгжийн үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллахыг Цагдаагийн газар (Б.Мөнхбат), Татварын хэлтэс (М.Туяацэцэг), холбогдох сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.	ХБТХОХ ЦГ ТХ сумдын Засаг дарга нарт	Луус, Хулд, Дэрэн, Сайхан-Овоо, Сайнцагаан, Дэлгэрхангай, Дэлгэрцогт, Эрдэнэдалай, зэрэг 8 сумын 17 худалдааны газар, 3 зоогийн газар нийт 20 ААН-д тусгай зөвшөөрөл олгож орон нутгийн орлогын дансанд нийт 13.2 сая төгрөг төвлөрүүлэн ажилласан.	100
11	A/56	Тэргүүлэх чиглэл батлах тухай 2024.02.07	11	2. “Хоршоог хөгжүүлэх сан”-гийн тэргүүлэх чиглэлийн хэрэгжилтэд хяналт тавьж, ажиллахыг Хүнс, хөдөө аж ахуйн газар (Б.Мөнхжаргал)-д даалгасугай.	ХХААГ	8 сум тэргүүлэх чиглэлээ батлуулсан. Үлдсэн 7 сум тэргүүлэх чиглэлээ батлуулахаар бэлтгэн ИТХ хуралдахыг хүлээж байна. Тэргүүлэх чиглэлээ батлуулсан сумдаас Сайнцагаан, Говь-Угтаал,	50

						Өндөршил, Дэрэн нар төсөл хүлээн авах зарыг олон нийтэд хүргээд хүлээн авч байна.	
12	A/57	Архи согтууруулах ундаа худалдан борлуулах, түүгээр үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл олгох тухай 2024.02.07	12	2.Гарсан шийдвэрийг холбогдох газруудад хуулийн хугацаанд мэдэгдэхийг Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс (Л.Доржбат), тухайн аж ахуй нэгжийн үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллахыг Цагдаагийн газар (Б.Мөнхбат), Татварын хэлтэс (М.Туяацэцэг), холбогдох сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.	ХБТХОХ ЦГ ТХ сумдын Засаг дарга нарт	Дэлгэрцогт, Сайнцагаан, Адаацаг, Өндөршил,Өлзийт, Цагаандэлгэр, Баянжаргалан, Сайхан-Овоо зэрэг нийт 8 сумын 16 худалдааны газар, 1 зоогийн газар нийт 17 ААН-д тусгай зөвшөөрөл олгож орон нутгийн орлогын дансанд нийт 11.0 сая төгрөг төвлөрүүлэн ажилласан.	100
13	A/58	Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны бүтэц орон тоо шинэчлэн батлах тухай 2024.02.08	13	2.Батлагдсан төсөв, бүтэц, орон тооны хязгаарт багтаан хуулиар тогтоосон хэм хэмжээний хүрээнд албаны чиг үүргийг үр дүнтэй зохион байгуулж ажиллахыг Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба (С.Бархасмаа)-д үүрэг болгосугай.	СХДАА	Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны бүтэц орон тоо шинэчлэн батлагдсантай холбогдуулан шинээр батлагдсан болон сул орон тооны 2 захиалгыг аймгийн ТАСЗөвлөлд хүргүүлсэн. Шинээр батлагдаж байгаа ахлах дотоод аудитор, дотоод аудиторын ажлын байрны тодорхойлолтыг боловсруулж батлуулахаар хүргүүлсэн.	70
14	A/64	Бага насны хүүхдийн цогц хөгжлийг дэмжих орон тооны бус орон нутгийн	14	2. Орон нутгийн зөвлөлийн ажиллах дүрмийг батлан, үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулж, арга хэмжээнд шаардагдах зардлыг улсын болон орон	НБХ	Бага насны хүүхдийн цогц хөгжлийг дэмжих арга хэмжээг 2024-2026 онд хөгжүүлэх төлөвлөгөөг батлан хэрэгжилтийг ханган ажиллаж байна.	30

		зөвлөл байгуулах тухай 2024.02.08		нутгийн төсөвт тусган хэрэгжүүлж ажиллахыг аймгийн Засаг даргыг Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга, ажлын хэсгийн ахлагч (Н.Эрдэнэ-Очир)-д даалгасугай.		Орон нутгийн зөвлөлийн ажиллах дүрмийг боловсруулан хэлэлцүүлгийн шатандаа явж байна. Төсвийн хувьд улсын төсвөөс 21,5 сая, орон нутгийн төсвөөс 28,0 сая төгрөг зарцуулагдахаар төлөвлөгдсөн.	
15	A/80	Ажлын тусгай горимд шилжүүлэх тухай 2024.02.17	15	2.Ажлын тусгай горимыг мөрдүүлж, Шуурхай штаб байгуулж, мэдээллийг аймгийн шуурхай штабт ирүүлж ажиллахыг аймгийн төрийн байгууллагын дарга, удирдлагуудад үүрэг болгосугай.	аймгийн төрийн байгууллагын дарга, удирдлагуудад	Аймгийн хэмжээнд гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжин ажиллах аймгийн Засаг даргын захирамжаар төрийн байгууллагын ажлыг цагийг уртасгасан цагаар аймаг, сумдын шуурхай штабыг 24 цагаар цагаар ажиллуулж Гамшгаас хамгаалах тухай хуулийн 10.4-т заасан арга хэмжээг хэрэгжүүлж, зудын гамшгийг хохирол багатай даван туулах арга хэмжээг зохион байгуулж судалгаа мэдээллийг нэгтгэн Улсын онцгой комиссын шуурхай штабт тухай бүр хүргүүлэн ажиллаж байна.	100
16	A/87	Сумдын Засаг дарга, Засаг даргын Тамгын газрын 2023 оны үйл ажиллагааны үр дүнгийн тухай	16	5. Сумдын Засаг даргын Тамгын газрыг удирдлага арга зүйгээр хангаж ажиллахыг Төрийн захиргааны удирдлагын	ТЗУХ	3 дугаар сард 15 сумдын Засаг даргын Тамгын газрын дарга нарт Өргөдөл гомдлын шийдвэрлэлт, Цахим аюулгүй байдал,	100


		2024.02.21		хэлтэс (Н.Түвшинжаргал)-т даалгасугай.		Гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, тайлагналтын талаар, Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж батлах, ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшин үнэлэх зэрэг сургалтуудыг зохион байгуулж хариуцсан чиглэл чиглэлээр мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч 2023 оны үйл ажиллагааны үр дүнгийн талаар Хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтсийн дарга Д.Даариймаа танилцуулж цаашид анхаарах асуудлын талаар чиглэл өгч ажилласан.	
17	A/95	Аймгийн түүх соёлын үл хөдлөх дурсгал зүйлийн улсын тооллогыг зохион байгуулах салбар комисс байгуулах тухай 2024.02.22 A/95	17	3.Түүх соёлын хөдлөх дурсгалт зүйлийн улсын тооллогыг холбогдох хууль, журам, удирдамжийн дагуу зохион байгуулж, тайлан мэдээг хугацаанд нь гарган танилцуулахыг ажлын хэсэг (Х.Цогзолмаа)-д даалгасугай.	СУГ	Улсын тооллого хийлгэх бэлтгэл ажлын хүрээнд аймгийн бүртгэл мэдээллийн сангийн тайлан мэдээ, байгууллагын тоон мэдээ, тооллогын "REGISTR" программын дата Соёлын өвийн үндэсний төвд хүргүүлэн ажилласан. Соёлын яам болон Соёлын өвийн үндэсний төвөөс албан ёсоор тооллого эхлүүлэх чиглэл ирж, тооллогын программ нээгддэг боловч тус байгууллагуудад зохион	ХБ

						байгуулалтын зарим асуудлаас шалтгаалан эхлэх боломжгүй хүлээгдэж байна.	
18	A/99	Аян зохион байгуулах тухай 2024.02.23	18	3. Архи, согтууруулах ундааны хор уршиг, түүнээс үүдэн гарах шууд болон шууд бус сөрөг нөлөөллийн талаар иргэд, олон нийтэд мэдээллийг түгээн, болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, гарсан зөрчлийг шуурхай таслан зогсоох арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Цагдаагийн газар (Б.Мөнхбат), Эрүүл мэндийн газар (Б.Алтантөгс), Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газар (Ц.Ганзориг), сумдын Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.	ЦГ ЭМГ ХГБХХГ сумдын Засаг дарга нар	Аяны арга хэмжээг эхлүүлж аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зөвлөл, Засаг даргын тамгын газар, аймгийн Мэргэжилтний баг, Цагдаагийн газар, Сайнцагаан сумын Засаг даргын тамгын газартай хамтран “Та татгалз-Бид дэмжье” сэдэвт зорилтот бүлгийн 22 иргэнийг хамруулан нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулж “Архи, согтууруулах ундаа, хүний биед үзүүлэх хор нөлөө, мэргэжлийн эмчийн хяналтад хийгдэж буй архины хордлого тайлах, архинд донтох эмгэгийн эмчилгээний талаарх мэдээлэл, “Говийн хийморь” АА бүлгийн ухаарлын яриа таниулга, “Хувь хүн өөрийгөө олох нь” сэдвээр сургалтыг хийсэн. Аймгийн Нэгдсэн эмнэлгээс архины хамааралтай 2 иргэнийг албадан эмчилгээнд явуулсан. Амбулаторийн үзлэгээр 3 дугаар сард архи хэтрүүлэн хэрэглэдэг	100

						9 хүнд сэтгэцийн нарийн мэргэжлийн эмчийн үзлэг, зөвлөгөөг өгсөн. Албан байгууллага, аж ахуйн нэгжүүдэд захирамжийг албан бичгээр хүргүүлж, аянд нэгдэхийг уриаллаа. Аймгийн ЗДТГ болон Эрүүл мэндийн газрын сайтад захирамжийг байршуулж бүх нийтэд уриалгыг гаргасан. Хандалт 287 байна.	
19	A/102	Сумдад аймгийн Засаг даргын аюулгүй нөөцийн өвс, тэжээлийг үнэгүй хуваарилан олгох тухай 2024.02.23	19	2. Дээрх ажлыг зохион байгуулж сумдад хуваарилан олгохыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Л.Доржбат), Хүнс, хөдөө аж ахуйн газар (Б.Мөнхжаргал) нарт даалгасугай.	ХХААГ	Аймгийн Засаг даргын 2024 оны 02 дугаар сарын 23-ны өдрийн А/102 дугаар захирамжаар 10000 боодол өвс, 2000 шуудай тэжээлийг сумдад хуваарилан олгосон.	100
20	A/110	Хурдан морины уралдаан зохион байгуулахыг хориглох тухай 2024.03.01	20	3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хүнс, хөдөө аж ахуйн газар (Б.Мөнхжаргал), Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газар (Ц.Ганзориг), Цагдаагийн газар (Б.Мөнхбат), Эрүүл мэндийн газар (Б.Алтантөгс)-т үүрэг болгосугай.	ХХААГ ХГБХХГ ЦГ ЭМГ	Аймгийн Засаг даргын захирамжийн дагуу хурдан морины уралдааныг 11 дүгээр сарын 01-ний өдрөөс 5 дугаар сарын 01-ний өдрийг хүртэл хугацаанд хурдан морины уралдааныг зохион байгуулахгүй байх талаар сумдад албан бичгийг хүргүүлж, илэрсэн зөрчлийг хурдан шуурхай шалгаж шийдвэрлэх холбогдох хуулийн дагуу арга хэмжээ тооцох талаар Хэсгийн мөрдөгч нарт	100

						үүрэг чиглэл өгсөн. Тус захирамжийг зөрчин хурдан морины уралдаан зохион байгуулсан асуудал гараагүй.	
21	A/122	Цэргийн албыг биеэр дүйцүүлэн хаах албанд иргэдийг авах, халах тухай 2024.03.07	21	2. Цэргийн албыг биеэр дүйцүүлэн хаах иргэнийг зарлан дуудаж, цэргийн дүйцүүлэх албаны бэлтгэл, тусгай үүргийн бэлтгэл шатны сургалтуудад хамруулах, хамрагдсан, дүйцүүлэн хаах хугацаа дууссан иргэнийг хасах, тооцоо, бүртгэл хийж дуусгахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штаб (Ө.Баясгалан)-д даалгасгай.	ЦШ	Мөнгөн төлбөр орлуулан хаах болзол хангасан 54 иргэнийг, хаахаас чөлөөлөгдсөн 45 иргэнийг нийт 99 иргэдийг цэргийн хоёрдугаар зэргийн бэлтгэл үүрэгтнээр тоо бүртгэлд бүртгэн авч цэргийн анхан шатны сургалтад хамруулахаар төлөвлөгөөнд тусгасан. 2024 оны 3 дугаар сарын байдлаар цэргийн дүйцүүлэх албыг мөнгөн төлбөрийн хэлбэрээр орлуулан хаасан иргэн байхгүй.	100
100 хувь-15, 70 хувь-2, 50 хувь-2, 30 хувь-1							88.5%

ХЯНАСАН: ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН ДАРГА
 НЭГТГЭСЭН: ТЗУХ-ИЙН НУТГИЙН ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГА ТАЙЛАН МЭДЭЭ
 ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН
 ХШҮ ХИИСЭН: ХШҮХ-ИЙН МЭРГЭЖИЛТЭН



Н.ТҮВШИНЖАРГАЛ
 А.ЦЭЦЭГДЭЛГЭР
 Б.СОЛОНГО